



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/82

Улаанбаатар хот

Салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, бэхжүүлэх
талаар авах зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоолоор Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын төрийн үйлчилгээний албан тушаалыг төрийн үйлчилгээний мэргэжлийн албан тушаалын ангилал, зэрэглэлд шилжүүлсэнтэй холбогдуулан доор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга нарт үүрэг болгосугай. Үүнд:

а. Ус цаг уур, орчны шинжилгээний төв болон цаг уурын өртөөнд ажиллаж байгаа мэргэжлийн бус албан хаагчдад хариуцсан ажлын чиглэлээр их, дээд сургуульд суралцах шаардлага тавих, ажиллангаа суралцах боломжийг олгох, дэмжлэг үзүүлэх;

б. Цаашид сул орон тоонд мэргэжлийн, дээд боловсролтой иргэнийг томилон ажиллуулах чиглэлийг баримтлах;

в. Ажлын онцлогоос шалтгаалан цаг уур, ус судлалын чиглэлээр цахимаар суралцаж байгаа албан хаагчид сургалтын төлөвлөгөөний дагуу танхимаар хичээллэх, шалгалт өгөх үед олговортой чөлөө олгох;

г. Их, дээд сургуулийн эчнээ (хоёрдогч бакалавр)-д суралцаж байгаа албан хаагчдад сургалтын төлөвлөгөөний дагуу зуны болон өвлийн 20 хоногийн танхимын сургалтад суух хугацаанд олговортой чөлөө олгох;


д. Албан хаагчдад цаашид ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын шинэчлэл, хөгжлийн хандлагатай уялдуулан ажлын байранд тавигдах мэргэжлийн шаардлагын талаар таниулах;

е. Үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийнхээ ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад цаг уур, орчны шинжилгээ, ус судлалын мэргэжлийн онцлог, мэргэжлийн давуу талыг сурталчлан таниулах арга хэмжээг жил бүр хөтөлбөрийн дагуу зохион байгуулж хэвших эдгээр болно.

2. Тушаалын хэрэгжилтийг жил бүр тайлагнахыг Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, аудитын хэлтэс (Р.Бадмаадорж)-т даалгасугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА



d:\2025\а тушаал\05.14-82.docx 151250243